

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2019.12.25-2019.01.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Засаг даргын 2018 оны 12-р сарын 04-ний өдрийн А/177 дугаар Захирамжаар 2018 оны жилийн эцсийн хүн ам, мал тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг томилон 12-р сарын 07-ны өдрөөс тооллогын ажлыг зохион байгуулж ажилласнаар 1079 өрхийн 3571 хүн ам, 50421 толгой мал тоологдсон нь урьд оноос хүн ам 122 өсч, мал 2384 толгой буюу 9,5 хувиар өссөн байна.

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 19 дүгээр хуралдаанаар Сумын эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2019 оны төсвийг батлуулсан.

Сумын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж албан байгууллагуудын мэдээлэлтэй танилцан байгууллагуудын удирдлагуудад холбогдох чиглэлийн дагуу хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Сумын төв шинэ жилийн баяр наадмыг 2018 оны 12-р сарын 30-ны өдөр 3-р сургуулийн спорт зааланд ёслол төгөлдөр тэмдэглэж сумын “Тэргүүний ажилтан”-аар - 2, Сумын Засаг даргын “Баярын бичиг”-ээр – 2, сумын “Тэргүүний залуу”-аар-2 иргэн тус тус шагнагдлаа. Мөн шинэ жилийн баярыг тохиолдуулан сумын иргэдийн дунд “Эрүүл бэлэг” аян өрнүүлж амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой болон хөгжлийн бэрхшээлтэй, хагас, бүтэн өнчин 150 хүүхдэд гардуулсан.

2018 оны “Тэргүүний ажилтан”-аар

1. О.Болормаа – ЗДТГ-ын Нутгийн захиргаа, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
2. Б.Энхцэцэг – Эрүүл мэндийн төвийн нярав нар шалгарсан бол

2018 оны “Тэргүүний залуу”-аар

1. Б.Ууганбаяр – ЗДТГ-ын архив, бичиг хэргийн эрхлэгч
2. Х.Сувданцэцэг - Эрүүл мэндийн төвийн эмч

Засаг даргын баярын бичгээр:

1. А.Энхтүвшин – Илчлэг-Шивээ ОНӨҮГ-ын селесар
2. Т.Жигжсүрэн – Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч нар тус тус шагнагдсан байна.



Сумын Засаг даргын 2018 оны А\196 дугаар захирамжаар “Боржигин голомт – Болор цом 36” яруу найргийн улсын уралдааны хүрээнд суманд зохион байгуулагдах “Уран үгсийн чуулган”-ыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон 2019 оны 01дүгээр сарын 04-ны өдөр ЕБС-ийн урлаг зааланд ёслол төгөлдөр зохион байгуулж 150 гаруй иргэд хамрагдсан байна. Уг чуулганд УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг болон монголын яруу найргийн түүх болсон 9 яруу найрагч зохиолчид оролцсон.



Сумын Засаг даргын 2019 оны 01-р сарын 07-ны өдрийн А/02 дугаар Захирамжаар Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах комисс томилогдон ажиллаж сумын хэмжээнд нийт 905 иргэн хамрагдахаас 708 иргэн хамрагдаж 78,2 хувьтай бүртгэгдсэн байна.

Сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 2019 оны 01-р сарын 09-ний өдөр зохион байгуулж Сумын “Аварга малчин”-аар– Т.Баттөмөр, Б.Хашхүү, Ц.Дэжид, Сумын “Алдарт уяач”-аар Д.Базарсүрэн, Ш.Лхамсүрэн нарыг шалгарууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 05 дугаар тогтоолоор батлагдсан өвлийн спортыг дэлгэрүүлэх сурталчлах зорилгын хүрээнд аймгийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан “Хаялга нуурын жавар” өдөрлөгт амжилттай оролцсон.



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 19-р хуралдаан 2018 оны 12-р сарын 11-ний өдөр зохион байгуулагдаж 6 асуудлыг хэлэлцэн баталсан.

Шивээговь сумын ГХУСАЗСЗ-өөс ерөнхий боловсролын сургуулийн 6-9, 10-12-р ангийн сурагчдын дунд гар зургийн уралдааныг 2018 оны 11-р сарын 07-13-ны хооронд зохион байгуулж 6-9-р ангийн сурагчдын төрөлд ТЭРГҮҮН байранд 7Б ангийн сурагч Х.Үйтүмэн, ДЭД байранд 8А ангийн сурагч Г.Энхжин, 10-12-р ангийн төрөлд ТЭРГҮҮН байранд 11А ангийн сурагч Э.Зулсаран, ДЭД байранд 12А ангийн сурагч Э.Золжаргал нар шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйл болон Төрийн банкинд 10,000 төгрөгийн хадгаламжийн дэвтэр нээж гардуулсан.



ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2018 оны жилийн эцсийн орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 57878,5 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэл 65619,4 мянган төгрөг төвлөрч 113 хувийн биелэлттэй ажилласан байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2018 оны жилийн эцсийн мэдээг гаргаж ТЗУХ-т хүргүүлсэн. Үүнд:

2018 онд Засаг дарга болон засаг даргын Тамгын газарт 115 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 1045 нийт 1160 өргөдөл хүлээн авч 1158 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Өргөдөл, гомдолын шийдвэрлэлтийн явц 99,8%-тай байна.


Шинэ жилийн баярын өдрүүдээр Засаг даргын Захирамжаар сумын хэмжээний хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган хуваарийн дагуу 5 байгууллагын 13 ажилтан, албан хаагчид эргүүл хийж ажиллахад тухайн өдрүүдэд тайван амгалан байлаа.

Аймгийн татварын хэлтэс 2019 оны 01-р сарын 18-ны өдөр суманд ажиллаж Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу орон сууцны чөлөөлөлт болон сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах иргэдэд Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн (цэнхэр) дэвтэр олгож, татварын буцаан олголтод хамрагдахад бүрдүүлэх материалын талаар заавар, зөвөлгөөг 96 иргэнд өгч ажилласан.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ :

2018-2019 оны хичээлийн жилд БСШУСЯ, Дэлхийн банкны хөрөнгө оруулалт сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн IV шатны шалгаруулалтыг улс орон даяар бага ангийн суралцагчдын сурах орчин, бага насны хүүхдүүдийг эх хэлээрээ зөв уншиж сурах, ярих чадварыг хөгжүүлэх зорилгоор тус уралдааныг зарласан билээ. Энэхүү уралдаанд оролцох, бэлтгэл хангах үүднээс Говьсүмбэр аймгийн БСУГ-ын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн С.Энх-Амгалантай хамтран бага ангийн багш нартаа төсөл хэрхэн бичих талаарх сургалтыг 2019 оны 01 сарын 03-ны өдөр сургууль дээрээ зохион байгуулж бага ангийн 13 багш, сургуулийн захирал, бага ангийн сургалтын менежер, дотуур байрны багш, нийгмийн ажилтан нийт 18 багш хамрагдсан.



“Багшийн хөгжил – Сурах бичиг” эрдэм шинжилгээний II бага хурал 01 сарын 16-ны өдөр аймгийн БСУГ-т зохион байгуулагдаж I шатанд тэргүүлсэн сургуулиудын 13 багш нарын илтгэл тавигдлаа. Үүнд хамт олноо тэргүүлсэн бага ангийн багш Ц.Одончимэг ахлагчтай баг оролцож аймагтаа 3 дугаар байранд шалгарсан.



2018-2019 оны хичээлийн жилийн II улирал дуусахатай холбогдуулан суралцагчдынхаа мэдлэг чадварын үнэлгээг судлагдахуун бүрээр хийж үнэлгээ дүгнэлт өгсөн. Үүнд бага ангийн I ангийн нийт 91 суралцагчаас унших чадвараар, II-V ангийн нийт 319 суралцагчаас хүн ба орчин, хүн ба байгаль хичээлээр, ахлах дунд ангийн суралцагчдаас судлагдахуун бүрээр мэдлэг чадварын үнэлгээг хийсэн.



Төрийн байгууллагад он удаан жил ажиллаж байгууллага хамт олноо ажил хөдөлмөрөөрөө манлайлан ажилласныг төр засгаас үнэлж бага ангийн сургалтын менежер О.Алимаа, орос хэлний багш С.Эрдэнэчимэг, түүх нийгмийн багш Г.Зоригт нар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар тус тус шагнагдсан.

II улирал дуусахтай холбогдуулан “Үдийн цай” хөтөлбөрийн үйл ажиллагааг явуулдаг Сүмбэр Шүтээн ХХК -ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийж үдийн цайны үйл ажиллагаа 90,3%-тай үнэлэгдэж хамтран ажиллах гэрээг сунгаж ажиллах саналыг сургуулийн захиргаанд уламжилсан.

3-Р ЦЭЦЭРЛЭГ

Цэцэрлэгийн хүүхдийн ирц он гарсаар бага насны хүүхдийн өвчлөл болон сургуулийн сурагчдын амралт эхэлсэнтэй холбогдуулан буурсан бөгөөд дунджаар 128-140 хүүхэдийн ирцтэй байна.

Цэцэрлэгийн үндсэн барилгын ариун цэврийн өрөө болон гал тогоонд халаагчтай усны цорго суурилуулсан.

Цэцэрлэгийн арга зүйч болон 10 багш Улаанбаатар хотод Сургуулийн өмнөх боловсролын шинэчлэл ТББ-аас зохион байгуулсан “Цэгээр наадъя-бага насны хүүхдийг зурлага бичвэрээр хөгжүүлэх нь сэдэвт арга зүйн сургалтанд хамрагдсан.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 68 өвчтөн хэвтэж үүнээс 53-н хүүхэд хэвтэн эмчлүүлж байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

- Амбулаторийн үзлэг -620
- Урьдчилан сэргийлэх –155
- Дуудлага- 268 ирсэнээс алсын дуудлага -12, хүүхдийн-173 ирсэн байна.

Хүйтний улирал эхэлсэнтэй холбогдон бага насны хүүхдийн болон насанд хүрэгчдийн ханиад томуугийн өвчлөл ихэсч хэвтэн эмчлүүлэгчдийн ор, өрөө палат

хүрэлцээхгүй сургуулийн дотуур байрны хүүхдийн ор, ЭМТ-ийн эмчийн өрөө, сургалтын өрөөг ашиглаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн 70-80 хувийг хүүхдийн өвчлөл эзэлж байна.

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 01 сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаал болон сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны 01 сарын 06-ны өдрийн А/03 дугаар тушаалаар эмч, эмнэлгийн ажилчид 08:30-19:30 хүртэл уртасгасан цагаар ажиллаж байна.



Иргэдэд томуу, томуу төст өвчний талаар урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмжийг цахимаар хүргэж сургууль, цэцэрлэгийн нийт 15 ангид томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх цэгэн массаж хийх самбар байршуулсан.

Дархан бүжгийн фестиваль-2018 Улсын анхдугаар уралдаанд Бүжгийн дугуйлангийн 33 сурагч оролцож Шивээн ганхаа-3 хамтлаг Алтан медаль, Шивээн ганхаа-4 хамтлаг Хүрэл медаль хүртсэн.



Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны 1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7 нэр төрлийн 92 ширхэг номыг 2018 оны 12 дугаар сард худалдан авч сумын нийтийн номын сангийн фондыг нэмэгдүүлээд байна.



Сар шинийн баярыг угтан байгууллагад харъяалалтай 3 өндөр настанд хүндэтгэл үзүүллээ. Мөн Шивээговь сумандаа амьдардаг ганц бие харж хандах хүнгүй ахмад настан Ж.Цэрэнсодномд сар шинийн тавгийн идээний хэвийн боов, цайны сүүтэй бэлгэлсэн.



УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 22 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 3 иргэн бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

01 сард газраа анх удаа өмчилж авч байгаа 5 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна.

Иргэдээс энэ сард 15 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

2018 оны архивын материалыг цэгцэлж нийт 33 нэгжийн 2369 бүхий хуудастай материалыг аймгийн УБХ-ийн архивын тасагт хүлээлгэн өгсөн. Уг нэгжээс байнга хадгалах хадгаламжийн нэгж 18, түр хадгалах 15 нэгж байна.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2019 ОНЫ 01 САРЫН МЭДЭЭ

| | м/д | Бүгд | Үүнээс: | | | | | |
|---------------------------------|-----|------|---------|---------|---------|-------|---------|---------|
| | | | Хот | | | Хөдөө | | |
| | | | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| Төрсөн хүүхэд | 1 | 3 | | | | 3 | 1 | 2 |
| Төрсөн эх | 2 | 3 | | | | 3 | | 3 |
| Бүртгүүлсэн гэр бүл | 3 | 2 | | | | 2 | 2 | 2 |
| Нас баралт | 4 | - | | | | - | - | - |
| Цуцалсан гэр бүл | 5 | - | | | | - | - | - |
| Үрчлэгдсэн хүүхэд | 6 | - | | | | - | - | - |
| Аймаг, нийслэлээс шилжин ирсэн | 7 | - | | | | - | - | - |
| Аймаг, нийслэл рүү шилжин явсан | 8 | - | | | | - | - | - |

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

2019.01.17

| д/д | Үйлчилгээний нэр төрөл | 2019 оны 01-р сар | | | | | Бүгд | Тайлбар |
|-------------------------|------------------------|--|-----------------|-------|---|-------|------|---------|
| | | Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд | | Бүгд | Тэмдэгтийн хураамж 3003001231 38 тоот дансанд | | | |
| | | Нэг бүрийн үнэ | Тоо | | Нэг бүрийн үнэ | Тоо | | |
| 1 | Эцэг тогтоосны бүртгэл | 2500 | 1 | 2500 | | | | |
| 2 | Гэрлэлтийн бүртгэл | 2500 | 2 | 5000 | | | | |
| 3 | Сум доторх шилжилт | 1500 | 5 | 7500 | 1000 | 5 | 5000 | |
| Дүн | | 15000 | | | 5000 | | | |
| д/д | Үйлчилгээний нэр төрөл | Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд | | Бүгд | Тэмдэгтийн хураамж 3003001231 38 тоот дансанд | | Бүгд | Тайлбар |
| | | Нэг бүрийн үнэ | Тоо | | Нэг бүрийн үнэ | Тоо | | |
| | | 4 | Иргэний үнэмлэх | 15000 | 3 | 45000 | 3300 | 3 |
| Дүн | | 45000 | | | 9900 | | | |
| Нийлбэр дүн | | 60000 | | | 14900 | | | |
| Нийт орлогын дүн | | 74900 | | | | | | |


МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ

Сумын онцгой комиссын хурлыг 2019 оны 01-р сарын 10-ны өдөр зохион байгуулж гахайн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу суманд гахай малладаг 3 өрхийн гахайн байранд ариутгал хийж, гахайн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг хүргэн ажиллаж байна. Мөн сумын цагдаагийн хэсэгтэй хамтран орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 9 дэлгүүр, 2 нийтийн хоолны газарт хяналт шалгалт хийж сэрэмжлүүлэг, зөвлөмж өгч ажилласан.

Суманд отроор яваа айл өрхүүдээр тойрч 4 өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт шалгалт хийж ажиллахад бүгд 2018 оны вакциндаа хамрагдсан байна.

БАЙГАЛЬ ОРЧИН

Бүх нийтийн их цэвэрлэгээг 2018 оны 12-р сарын 18, 30-ны өдрүүдэд болон 2019 оны 01 сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулж давхардсан тоогоор 53 аж ахуйн нэгж байгууллагын 330 иргэн 72,5 га талбайн 90м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Сумын "Ахуйн хог хаягдлыг тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн хогийг цэвэрлэж, булах" ажлын гүйцэтгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 03-нд хүлээн авсан. Уг ажлын санхүүжилт 2019 оны төсөвт тусгагдсан тул 2019 онд ЗДТГ хариуцан гүйцэтгэхээр ажилгүй 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаад байна.

Сумын 2019 оны ОНХС-ийн 161,2 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдэх 12 арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан Tender.gov.mn, шилэн данс, сангийн яамны сайт, shiveegovi.gov.mn зэрэг цахим хуудаст байршуулсан.

МЭДЭЭ ГАРГАСАН: НЗЭЗАХМ

О.БОЛОРМАА

ХЯНАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ